

Орон бүгдийн пролетари нар нэгдэгтүн!

# Днхэ дугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,  
АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ СӨНИН.

14 дөх жилдээ 1962 оны 2 дугаар сарын 22 ПҮРЭВ № 12 (1156)

## Социалист уралдааны олон хэлбэрийг чадамгай ашиглая

Манай оронд социализм байгуулахад ажилчин олныг идэвхжүүлэн зохион байгуулах шалгарсан арга болсон социалист уралдааныг олон хэлбэрээр өрнүүлэх явдал мөн.

Энэ ажил нь ялангуяа үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын үндсэн бөгөөд чухал зорилт, түүний бүх ажлын хэмжүүр нь байх ёстой.

Улс ардын аж ахуй, соёлын бүх салбарт социалист үйлдвэрлийн харилцаа ялсан, манай орны одоогийн төхөөрөлд социалист уралдааныг бүх талаар өрчимтэй өрнүүлэх нь шинэ шинэ бололцоог нээн өгч, түүнийг улам баялаг агуулга хэлбэртэй болгож байна.

Манай аймгийн үйлдвэр, аж ахуй, үйлчилгээний газар, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас социалист уралдааныг өрчимтэй өрнүүлэн, ажлаа чиглүүлэн зохиож, шинэ бүтээл, оновчтой саяал, төрүүний туршлагыг дэмжин дэлгэрлэх ажил нилээд эрч олж байгаагаас үйлдвэр, аж ахуй, үйлчилгээний газруудын ажилчдаас социалист уралдаанд урт богино хугацаагаар тодорхой үүрэг амлалт авч нийтийг уриалах явдал өрнөж байна.

1961 онд аймгийн үйлдвэрчний эвлэлийн зөвлөл, үйлдвэр, аж ахуйн газруудтай хамтарч социалист уралдаанд шалгаруулах болзол 17 удаа гаргаж дүгнэн, социалист уралдааныг олон хэлбэрээр өрнүүлэх талаар 24 удаа семинар, зөвлөлдөр өгч, түүнд 2463 хүн хамруулжээ.

Үүний үрээр аймгийн хэмжээгээр социалист уралдаанд үйлдвэр, аж ахуйн 17 газар үүрэг авсны 15 нь үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 100-125 хувиар биелүүлж социалист уралдаанд хамрагдсан 2815 ажилчин нэрмээ 100-150 хувиар биелүүлжээ. 1962 онд аймгийн үйлдвэр, аж ахуйн газрууд МҮЭ-ийн 8 дугаар их хурлыг уртгаж социалист уралдааныг өрнүүлэн өндөр үүрэг амлалт авч байна.

Их Хайрханы уулын үйлдвэр, 1 дүгээр сарын төлөвлөгөөгөө 101 хувиар биелүүлж, 1962 оны вольфрам гаргах төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө 102 хувиар биелүүлж, хөдөлмөрийн бүтээлийг 1,5 хувиар нэмэгдүүлэн, 1962 оны эхний хагас жилд 20-нос доошгүй шинэ санаачлага гаргаж, үйлдвэртээ 120 мянган төгрөгийн ашиг оруулах, Жаргалантын САА, авто тээвэрийн 13 дугаар бааз зэрэг олон газар малын төлийг бүрэн бойжуулах, ажилчин бүр нормоо давуулан биелүүлэх үүрэг аваад тусгай болзол гарган ажиллаж байна.

Гэгэ социалист уралдааныг зохион байгуулж удирдах туслах олон хэлбэрийг чадамгай ашиглан өрнүүлэх талаар ҮЭ-ийн байгууллага,

үйлдвэр, аж ахуйн газруудын ажилд багагүй дутагдал оршоор байна.

Социалист уралдааныг зохиох, үүрэг болзлыг боловсруулахдаа үйлдвэрлэлийн программыг олси түмэнд урьдчилан сайн таниулж төдний санал зөвлөлгөөнийг авахын оронд бодит байдлыг тусгаагүй өрөнхий үүрэг амлалт авах, уралдааныг тодорхой хугацаанд дүгнэж, шагнал урамшил олгохгүй, уралдааны тугийг тойруусан олон хэлбэрийн ажил зохиохгүй байна.

Иймд социалист уралдааныг өрнүүлэх ажилд оршиж байгаа дутагдлуудыг арилгаж, социалист уралдаанд авсан үүргийн биелэлтийг харилцан шалгаруулах, уралдааны явцын тухай хурал зөвлөлгөөнөөр хэлэлцэж, хоцрогдлыг арилгаж байх нь ҮЭ-ийн байгууллагын анхаарлын төвд байх ёстой.

Социалист уралдааныг сурталчлах олон хэлбэрүүдийг гүйцэтгэж ажилчин, бригад, тасаг, ээлж, үйлдвэр аж ахуйн газраараа авсан үүргээ бичиж ил тавих, цахилгаан сонин, дайчин, мэдээлэх хуудас, дэмжих дэвтрийг өдөр дутам ажиллуулах, ханын сонин, төв орон нутгийн сонин сэтгүүлд бичих, уралдаанд амжилт гаргагчдаар өөрөөр нь яриулах, үндэслэг, уулзалт зохиох, уралдааны булан байгуулж, хөдөлгөөнт самбарууд ажиллуулах, мэргэжлийн төрлөөр нь уралдуулах, алтан хайрцаг нээх, туг булаацалдах хэлбэрийг дүүрэн ашиглавад зохино.

Ингэж олон хэлбэрийг ашиглан уралдаанд авсан үүрэг, болзуудад олсон амжилт, шинэ бүтээл, оновчтой санааууд, социалист хөдөлмөрийн бригадын хөдөлгөөн түүний туршлагыг байнга дэмжин дэлгэрүүлж ажиллах нь үйлдвэр, аж ахуйн газар, үйлдвэрчний эвлэлийн бүлэг, хороодын хойшлуулагшгүй чухал зорилт мөн.

### ШЕФ БАЙГУУЛАГДАВ

Саяхан Их Хайрханы уурхайн уулын цех, цахилгаан станцин ажилчинд Ванбарат сумын Ван-амьдрал нэгдлийн 4 дүгээр бригадтай шеф байгуулав.

Уулын цех, цахилгаан станцианх 4 дүгээр бригадын малын төл хүлээн авах, мал хаваржуулах ажилд нь туслан төлийн уут, нөмнээ зэргийг өгч, нэг суурьт саравчтай тохилог хамна барьж өгөв.

Олоо бригадын төвд улаанбулан, барьж өгөхөөр бэлтгэж байна. Энэ нь манай ажилчин МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын шийдвэрийг биелүүлэн, мал аж ахуйн ажилд их анхаарал тавьж байгаагийн бараат мөн. Д. Лодон

## Намын үзэл суртлын ажлыг дээшлүүлэхэд үнэт сургамж боллоо

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн намын төв хорооны нарийн бичгийн дарга Д. Төмөр-очир, 2 дугаар сарын 21-нд тус аймагт 1рх. Гэмтэй төвийн намын гишүүд, хөдөлмөрчидтэй уулзав. Д. Төмөр-очир, МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын дүргийн тухай дэлгэрэнгүй ярих. Д. Төмөр-очир хэлэхдээ: МАХН-ын Төв Хорооны II бүгд хурал, Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын 22 дугаар их хурлын дайчин хувьсгалч үзэл санаагаар амьсгалж, түүний үйл ажиллагааг ажил амьдралдаа тусган хэрэглэж, нэг хүнийг тахин шүтэхийн хор хохирыг уудлан илрүүлж, нам улс олон нийт, аж ахуйн байгууллагуын ажил дээр оршиж байгаа дутагдал, ялангуяа мал аж ахуйн хоцрогдлыг арилгах талаар түүхэн чухал шийдвэр гаргасныг онцлон тэмдэглэв.

Д. Төмөр-очир нааш нь хэлэхдээ: Мал аж ахуйн хоцрогдлыг арилгахад хөдөө аж ахуй дээр ажиллаж байгаа намын гишүүд, хариуцаагчнууд, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага, сахилга батыг эрс өндөржүүлж, мал аж ахуйг шинэ арга барилаар мэдлэгтэй удирдах, мал сүргийг өсгөж, ашиг шинийг нэмэгдүүлэх, газар тариаланг хөгжүүлэх нөөц бололцоог нээн илэрүүлэх явдал хурцаар шаардагдаж байна гэв.

Д. Төмөр-очир, үгнийхээ төгсгөлд манай намын байгууллагууд үзэл суртал, ухуулга олон түмний ажлыг аж ахуйн ажлаас тасархай зохиодог ноцтой дутагдлыг арилгаж, намын үзэл суртал, ухуулгын бүх ажлыг аж ахуйн өэлжит зорилготой

нягт холбоон, төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд хөдөлмөрчдийн улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэхүйц дайчин далайцтай зохиох нь чухал гэж заав.

Уулзалтанд Алтанбулаг сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Халзан хэлсэн үгэндээ: Намын Төв Хорооны II бүгд хурлын түүхэн шийдвэр бол эх орондоо социализмыг бүрэн төгс байгуулах явцыг улам түргэтгэхийн тулд манай ажилд оршиж байгаа саад тотгорыг үндсээр нь илрүүлэн зааж, ялангуяа мал аж ахуйн удаан жилийн хоцрогдлыг арилгаж, мал аж ахуйг хөгжүүлэх талаар зөв мөргөн шийдвэрийг гаргаснаараа манай орны хөдөлмөрчдийн ажиллах урам зоргийг улам нэмэгдүүлж байна.

Манай сум-нэгдлийн хамт олон намын энэ шийдвэрийг ажил амьдралдаа хэрэгжүүлэн, төл бүрийг мал болгох тэмцэлд бүх хүчээ дайчлан, намын үзэл суртал, зохион байгуулалтын ажлыг шаардлагын хэмжээнд хүртээлэй сайжруулж чадна гэж үүрэг авлаа.

Аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн захирал Мянганбуу, артелийн СХ бригадын ахлагч Тавхай нар үг хэлэв.

МАХ Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д. Төмөр-очир, тус аймгийн орон нутгийг судлах музей, нийтийн номын сан, намын кабинетыг үзэж, аймгийн төвийн нам, улс олон нийт, эмнэлэг, гэгээрлийн газрын удирдах нөхөд намын үзэл сурталын ажилтнуудтай уулзаж төдний эрэлт хүсэлтийг хүлээн авав.

Д. Дондогдорж.

## Үзэсгэлэн хаалаа

Польшийн Ажилчны Нэгдсэн Намын 20 жилийн ойд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн, аймгийн төвд 7 хоног ажиллаад 2 дугаар сарын 21-нд хаагдлаа.

Үзэсгэлэнг хяаж Польшийн элчин сайдын яамны ажилтан Станислав Чекальский товч үг хэлэв.

Тэр хэлэхдээ: ПАНН-ын тухай үзэсгэлэнг өнөөдөр хяаж байна.

ПАН Нам, дайны хүнд бэрх үед ард түмнээ Финштын эсрэг тэмцэлд зохион байгуулж, эх орноо чөлөөлсөн юм.

Манай нам нь улс орноо социализмын замаар жолоодон их амжилт олж байна.

Улаанбаатарт байгуулагдсан үзэсгэлэн олон мянган хүн сонирхон үзлээ.

Танай энд нээсэн энэ үзэсгэлэн, манай хоёр орны найрамдлыг улам бэхжүүлэхэд ач холбогдолтой боллоо. Энэ үзэсгэлэнг байгуулахад тусалсан МАХН-ын Төв Хороо, Төв аймгийн намын хороонд халуун талархлаа илэрхийлж гэв.

Дараа нь Аймгийн АДХГ захиргааны дарга Жамаран товч үг хэлэв.

Жамаран хэлэхдээ: Польшийн Ажилчны Нэгдсэн Нам, байгуулагдсан 20 жилийн түүхэн ялалтын ойг тохиолдуулан, Польш ард улсын ард түмэн, ажилчны намынхаа мөргөн удирдлагаар ардын хувьсгалын жилүүдэд улс ардын аж ахуйн салбар бүхэнд олсон амжилтыг харуулан үзэсгэлэн, «Өнөөдөр манай Польш» гэдэг кино сэтгүүлийг манай аймгийн төвд 2 дугаар сарын 14-21 хүртэл 7 хоног ажиллууасныг манай хөдөлмөрчид сэтгэл хайгамжтай сонирхлоо.

Үзэсгэлэнг 3417 хүн, кино сэтгүүлийг аймгийн төв, хөдөөд 1558 хүн үзжээ.

Үзэсгэлэнгийн улс төрийн ач холбогдлыг манай аймгийн ажилчин, малчин, сэхээтэн 30 гаруй хүн, 10 гаруй албан байгууллагын хамт олон үеү ёсоор үнэлэн үзэж сэтгэгдлээ бичсэн байна.

Үзэсгэлэнгийн сэтгэгдлийн дэвтэрт бичсэн, хүн бүхэн Польш улсаас ингэж үзэсгэлэнг байгуулж, өөрийн орны амжилт хөгжилтийг сурталчилсанд баяр хүргэж, Польшийн ард түмэнд аз жаргал, сайн сайхныг хүсэн, Монгол-Польшийн ард түмний найрамдал, МАХ Нам, Польшийн Ажилчны Нэгдсэн Намын хамтын ажиллагаа улам бэхжтүгэй гэж өрөөсөн байна.

Энэ нь манай хоёр орны ард түмний найрамдалт харилцааг улам бэхжүүлэхэд асар их ач холбогдолтой юмаа.

Хайрт нөхөд өө! БНПАУ-аас манай улсад суугаа элчин сайдын яам, ПАНН-ын үйл ажиллагаа, баатарлаг тэмцлийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн кино сэтгүүлд тус аймгийн хөдөлмөрчид, намын гишүүдэд өөрийн орны байдлыг тодорхой таниулж өгсөнд аймгийн намын хороо, АДХГ захиргаа, бүх хөдөлмөрчид, намын гишүүдийн өмнөс чин сэтгэлийн халуун талархлаа дэвшүүдье!

БНПАУ-аас тус аймагт байгуулсан үзэсгэлэнгийн ажиллагаа дуусч үзэсгэлэнг хаасныг мэдэгдье гэдэг, Монгол-Польшийн ард түмний ах дүүгийн найрамдлыг өрөө.

М. Сандуй

### Хорооны ажил сайжирч байна

Архустайн сургуулийн комбина-  
тын үйлдвэрчний эвлэлийн хороо  
(дарга нь багш Хандсүрэн) ажилч-  
дын аж байдал материаллаг сонирх-  
лыг нэмэгдүүлж, ажил дээрээ ам-  
жилт гаргах нөхцөлийг хангасан  
нилээд ажла зохиожээ.

Багш, ажилчдын нормд хэрэглээд  
зохио берзентэн бээлий, хөвөлтэй  
өмөд, цамц, эсгий гутал, хөвөлтэй  
бээлий халад цөмийг олгуулжээ.

Гэрийн дулаалганд зориулсан  
дээр, туурга, шалавч олгуулж,  
варим багш нарын цалингийн мар-  
гааныг барагдуулж, бүх амарвал,  
зохио багш ажилчдаа цөмий нь ам-  
руулсан байна. Түшгэлсэн байгуу-  
лагын ажилд туслахаар үйлдвэрч-  
ний эвлэлийн гишүүдийн  
хүчийг зохион байгуулж, барилгын  
чулуу кублэж, анги, байруудын 60

гаруй тасалгаа бүхий 10 гаруй бай-  
шинд засвар хийж шавардах, бу-  
дах, гэрэл тавих бүх ажлыг ам-  
жилттай дуусгажээ.

Үйлдвэрчний эвлэлийн хороо, сур-  
гуулийн мастер багш нарын хооронд  
уралдаан зарлан, болзол гар-  
гаж ажилласны дүнд сургуулийн  
1961-1962 оны нлчээлийн жилийн  
бүх түлшнийг 60 гаруй км газраас  
өөрийн хүчээр татуулсан байна.

Барилга засвар, түлш, татах  
ажилд багш Галсандаш, Ишжамц  
нар онц идэвхтэй оролцсон аж.

Гишүүдийн дунд соёл олон тү-  
мний ажлыг төрөл бүрийн хөлбэрээр  
зохиож, түшгэлсэн байгууллагын  
ажилд үйлдвэрчний эвлэлийн ги-  
шүүдийн хүчийг жигд дайчлан  
ажиллаж байна.

Д. Чулуун.

### Хууль сурталчлах 3 хоногт

Саяхан аймгийн шүүхээс Борнуур,  
сум-сангийн аж ахуйг гэмт хэрэг-  
гүй сум-сангийн аж ахуй болгох,  
танхай балмад явдалтай тэмцэх,  
социалист өмчийг хамгаалах зорил-  
гоор эрүү, иргэний ба гэр бүл, ас-  
рэмж тэтгэмжийн тухай хууль сур-  
талчлах 3 хоногийн ажил зохион.

Үүнд: 9 газар хурал зөвлөдөгөн  
болж, 1000 шахам хүнийг хамарчээ.

Залуу эмэгтэйчүүд, ахмадын зөв-  
лөлдүүд байгуули, олон нийтийн

шүүхийн тайланг тавиулан, эрүү-  
гийн гэмт зэргийн зарим үйлдлийг  
гаруулсан гар зургийн булан бай-  
лан ажиллуулжээ.

Тус аж ахуйн ногоочны бригадын  
дарга Бямба, агротехникч Шар, Цэ-  
рэндорж, Дугарсүрэн нар өөрсдийн  
хариуцсан бригад, фермүүдээ гэмт  
хэрэггүй бригад, ферм болгох үү-  
рэг аваад ажиллаж байна.

Норзод

### Тайлан тооцоог цэгцлэхийн төлөө

Гомбодорж ахлагчтай санхүү, үйл-  
чилгээний ажилчид, СХТ бри-  
гад байгуулан социалист ёсоор хам-  
тарч ажиллаж, амьдарч, сурахаар 1  
жилийн хугацаатай үүрэг авч ажил-  
лаад уг хугацаа дусч байна.

Энэ завсар нэг нь шийтийн төлөө  
нийт нь нэгийн төлөө социалист  
зан чанарыг өзөмшигээр чин сөтгө-  
лөөсөө зорьж ажилласны дүнд тай-  
лан бүртгэлийг сайжруулан анхан  
шатны бүх бүртгэлийг хөтөлж зар-  
им салбарт хууль дүрэм зөрчиж  
байгааг илрүүлэн засах, хөдөлмөр-  
рийн хуудсыг хөтлөх, баяансыг ху-  
гацаанд нь гаргах, өр дутагдал  
гаргахгүй байх зэрэг үйлдвэрийн  
амын чухал асуудал болсон 10 га-  
руй үүрэг авч биелүүлжээ.

Тус артедийн тайлан баланс зо-  
чих цагтаа бүрэн гарч чаддаг бо-  
лов.

Урьд онд байсан дутагдал шам-

шигдлыг 95 хувиар багасгаж өр  
авлагыг 59,9 хувиар хорогдуулан,  
дутагдал шамингдал гаргаагүй  
байна.

Бригад нь авсан үүргээ 137,5  
хувиар биелүүлж, төсөв Зардлаас  
33621 төгрөг хэмнэж 2 хүний аж-  
лыг нэг хүн хийж, галч зарлагын  
ажлыг бригадын гишүүд хийснээр  
1003 төгрөг хэмнэж, ажлын бус  
цагаар 12 айлын орон сууц барьж,  
120000 төгрөгийн хуримтлалыг  
үйлдвэртээ оруулжээ.

Энэ бригадынхан ажиллаж амьд-  
рах талаар авсан үүргээ амжилттай  
биелүүлж байна.

Сурах талын зарим үүрэг дутуу  
байгаа учир тус бригадын хамт  
олон дутуугаа гүйцээж дулилгаа  
дүүргэхийн тулд минут алдахгүй  
шаргуу ажиллах хэрэгтэй байна.

ЖАМБАА

### Төлөвлөгөө биелэв

Мөнгөнморьт сумын худалдаа  
бэлтгэлийн ангийн төвийн дэлгүүр,  
1962 оны 1 дүгээр сарын бараа  
гүйлгээний төлөвлөгөөг 18,3 хувиар  
давуулан биелүүлэв.

Худалдагч Санжаасүрэн 100 хувь,  
Магваан 118,3 хувиар, ном борлуу-

лах төлөвлөгөөг 105,4 хувиар тус  
тус биелүүлжээ.

Тус дэлгүүрийнхөн хөдөлмөрдөд  
үйлчлэх цагийн хуваарыг нарийн  
баримтлан, шуурхай үйлчилсний  
үрээр ийм амжилтанд хүрчээ.

Ж. Чулуун.

### Сурагчид, төл бойжуулахад

Урьхан хавар ирж, түмөн бо-  
диг дөлгөрөх цагийн эхэнд хээл-  
тэй малын хэвлэй дахь төл гарч,  
алтан дөлхийн хөрсөн дээр гвшгэн  
босч байгаа нь малчин монгол хү-  
мүүсийн уламжлалт их баяр байдаг  
билээ.

Хонь, ямаан сүрэг өдөр шөнөгүй  
хэдэн арваараа төлөх нь хүн бүх-  
ний хүч чадлыг дайчлах их ажил  
шаарддаг. Малчдын урам зо-  
риг нь улам бадарч, бие нь хөнгөрч,  
нойр нь сөргөж цагашгүй энэ их  
хөдөлмөрийн үр дүнд мянга мянган  
мал нэмэгдэв.

Малын төл хүлээн авч, бүрэн бой-  
жуулах нь социализмын өрнүүн  
байгуулалтын программыг биелүү-  
лэх олон талт ажлын дотроос гол  
зүйл мөн.

Энэ ажилд 8 настай балчраас эх-  
лэн, 80 настай буурдууд хүртэл  
чадлынхаа хирээр нэмэр больё гэ-  
сэн эх оронч хөдөлгөөн өрвөдөг.

Манай аймгийн олон сургуули-

дын сурагчид малын төл хүлээн  
авч бойжуулах ажилд асар их хувь  
нэмэр оруулж байна.

Сурагчид мал өвөлжилт, төлийн  
бэлтгэлд зориулан 850 нэмнээ, цас-  
ны 244 малтуур, 389 бээлий, төлийн  
183 уут, 954 элгэвч бэлтгэж нэгдэл,  
сангийн аж ахуйд өгчээ.

Батсүмбэр сумын Монхоодой ахлагч-  
тай бага сургууль, сангийн аж  
ахуйн үнээний бригадийг шөфлөн  
авч хашаа хороог засч дулаалж,  
тугай бойжуулах арга туршилагыг  
харуулсан самбар, зурагт хуудсууд  
хийж өгчээ.

Мөнгөнморьт, Баянжаргалан су-  
мны сургуулиа нэгдлээсээ 50-100  
төлөх хонь, ямаа хүлээн авч өөр-  
дийн хүчээр төлийн нь бойжуулах  
гэж байна.

Сургууль бүхэн нэгдлийн брига-  
дуудыг шөфлөн авсан байна.

Багш сурагчдын бүрэлдэхүүнтэй  
ухуулах бригадуудыг гаргаж  
маачдын дунд ажиллуулж байна.

Архуст, Баян, Батсүмбэр су-  
мны сургуулийн сурагчдын сахил-  
га эрс дээшилж, өнгөрсөн улир-  
лаар сургуулиараа 96-гаас 100  
хувийн сурлагын амжилт үзүүл-  
жээ. Энэ гурван сургуулийн 12  
багш ангиа 100 хувийн дүнтэй  
сургажээ.

Ингэж сурагчдын сурлагын ча-  
нар сайжраад зогсоогүй, хөдөл-  
мөрдийн боловсрол мэдлэгийг  
дээшлүүлэхэд энэ сургуулийнхан  
идэвхтэй ажиллаж, ерөнхий эрд-  
лийн анхан шатны боловсрол  
олгох 2 жилийн сургууль, оройн

сургуулиудыг байгуулж, сумын  
төвд суугаа анхан шатны боловс-  
ролгүй бүх хүмүүсийг хамарч  
байна.

ЗУРАГ ДЭЭР: Зүүн гараас  
Архустын бага сургуулийн эрх-  
лэгч Мажисүрэн, Баян сумыг  
бага сургуулийн эрхлэгч Гүнсэ-  
норов, Батсүмбэрийн бага сургуу-  
лийн эрхлэгч Монхоодой но-  
Монголын багш нарын 3 дугаар  
ах хурлын шийдвэрийг яаж биел-  
лүүлж байгаа туршилагаа ярил-  
цаж байгаа нь.  
Зургийг Давдай.

### ТАЙЛАН СОНГУУЛИЙН ХУРАЛ

Тарнат сумын Батхөгжил нэгд-  
лийн бүх гишүүдийн тайлан сон-  
гуулийн хурал саяхан болж, ерөн-  
хий хорооны дарга Доржсүрэн, 1961  
оны ажлын дүн ба 1962 онд тавих  
зорилтын тухай нлтгэл тавьлаа.

Доржсүрэн нлтгэлдээ: 1961 онд  
нэгдлийн нийгмийн малыг 104 ху-  
виар, сумын бүх малыг 110 хувиар  
өстөгөн ба тус нэгдэлд төргүүний  
сайчууд олширч байгааг хийсэн  
бүтээлээр нь тодорхой дурдаж,  
1962 онд бүх малаа өстөхийн зэрэг-  
цээгээр ашиг шимийн нэмэгдүүлж,  
үүдээр угсаагий нь сайжруулан,  
хөдөлмөрдийн аж амьдралыг улам  
дээшлүүлэх, үйлдвэр сайжруу-  
лэвдөгөөр яаж биелүүлэх талаар  
тодорхой ярьлаа.

Дараа нь 30 гаруй хүн санал  
шүүмжлэл гаргаж, ажил дээрээ үү-  
рэг амлалт авлаа.

Мөн хариуцсан суурь хонио 5  
сар оторлож уйгагүй дагаж харну-  
лсан үр дүнд хонь бүрийг дунд-  
аар 40-45 кг-д хүргэсэн, хоньчин  
Рэнцэн, Жагд, Цэрмаа, Ням нар бо-  
лон, нэгдлийн үйлдвэрийн төлөвлө-  
гөөг биелүүлэхэд их амжилт гар-  
гасан Жавзмаа, Нэржин, Цэрэн-  
дорж, Дамба нарын 40 гаруй хү-  
нийг сайшаалын үнэмлэх, «Эх орон  
52» хүлээн авалч зэрэг үнэ бүхий  
ауйлээр шагналаа.

Хуралд тус нэгдлийн шөф, МҮЭ-ийн  
Төв Зөвлөлийн удирдагууд болон,  
Нун сумын дарга, тамын үүгийн  
дарга нар уриалар орлцов.  
Дараа нь махкомбинатын уран  
сайханчдын концерт тоглоо.

Г. Базарсад

Одоо мал ид төлөж байгаа үед  
сурагчид улам их ажил хийх хэр-  
эгтэй болов.


Малчдад захидал бичиж зөвлө-  
гөө өгөх,ухуулах зурагт хуудас гар-  
гаж түүндээ төл бойжуулах талаар  
гарч байгаа сайн туршилагыг үзүү-  
лэх, хичээлийн чөлөө цагаар ойр  
байгаа суурь, бригад фермын төл  
бойжилтонд биелэн туслах хэрэг-  
тэй.

Төл бойжуулах ажилд сурагчдыг  
явз бүрийн хөлбэрээр оролцуулах  
нь залуу үеийг мал аж ахуйн  
ажилд дайлажжуулах их ач хол-  
богдолтой юм.

Ийм уранс сурагчдад төл бой-  
жуулж байгаа ажлын арга турш-  
лагыг азынчуулах ажлыг сургуу-  
лиуд тодорхой зохион байгуулбал  
зохино.

Ялангуяа төл хүлээн авах бэлт-  
гэлийг сайн хангаж төлөө сайн  
бойжуулж байгаа хот айлын үзүү-  
лэх арга хэмжээ авах нь чухал.

Доржламба



Төл болгоныг мал болгоосын төлөө!

### Төлчдөд туслаж байна

Архустай сумын бага сургууль «Төл болгоныг мал болгоё» гэдэг Төв Хорооны шийдвэрийг хүлээн аваад тус сагийн аж ахуйн үржил ховины 1 дүгээр фермийн Чөгсом ахлагчтай 6 дугаар суурийг шөфлэн авч тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тус сургуулийн сурагчид шөф суурьтаа төл «болгоныг мал бол-

гохын төлөө» гэсэн лозун, «пионер, сурагчдын шөф суурь» гэсэн хаяг, төлчдөд зориулсан ухуулах хуудас зэргийг хийж өгснөөс гадна элгэвч 1800, пайз 7650, уут 69, нэмнээ 119, гарын бээлий 218, цасны гагнуу 123, лаа 400 ширхгийг тус тус бэлтгэж малчдад туслаж байна.

Н. Мажигсүрэн

### Туршлагатай хоньчны түүштэй бүтээл

Их а яриа, хөгжөөн төй байрын Лувсандагва гуайг хонно харнуулж явахад нь дайрагдаж, мөнд усаа мэдэлцэвний дараа Лувсандагва гуайгаас:

— Мал ажиллагааныхаа туршлагаас ярьж өгнө үү? гэлээ.

— Ахад чинь арга туршлагасаад байх юм бараг байдаггүй хүн дээ.

Би нэгдээс 4 жил дараалан 500-900 эм хонь, ямаа авч маллаад жил бүр 200-300 хонь, ямаа төлүүлж төлөө хорогдолгүй бойжуулж ирлээ. Ер нь жилийн 4 улиралд малын хариулга, билчээр усыг тохируулж, тарга төвээрэг сайн авахуулаад, өвөл хаврын улиралд хүч таргаг буруулахгүй байж чадвал малын үс, ноос, сүү саалийн гарц сайн, гарсан төл нь доово сэргэлэн, чийрэг, бойжилт нь сайн байдаг юм.

Төллөх малын хариулга маллагааг улам сайжруулж хээл нь томорсон малыг нөмөр дулаан, зөөлөн цастай, нам дор газар харнуулах нь чухал.

Зун цагт хонийг аль ногоотой билчээр дагуудан маллаж, усаар ханган, өглөө, оройн сэрүүнд сайн идэшлүүлэх, намар бог малыг голын зах, дарс ихтэй сэрүүвтэр газар ширүүн тууж, үргээж цочоохгүй харнулдаг. Өвлийн цагт малыг цан хүүрэг арилсны дараа өртхөн билчээж оройтуулахгүй хотлуулах, билчээрийг дулаан хүйтний байдалд тохируулж, хуваартай ашиглах нь малыг дааруулж, тохь алдуулахгүй, авсан тарга хүний нь бууруулахгүй байхад нь ашигтай байдаг.

Манайх малаа өдөр бүр хужирдаж, төлөлтийн үеэр шөнө бүр

жижүүрлэж, төлөө хөрвийн аргаар өхтэй нь хамт бойжуулдаг.

Энэ нь нэгд хургаа голдоггүй, хоёрт гарсан төл өхийн уургийг цадалтаа хөхөж, тэсвэртэй, өнгөлөг, доово байдгийн гадна хуучин, гэрт бойжуулж байсны адил нэг даарч, нэг халууцаж, халуун хүйтэн хоёр хямарч, өвчин тусах явдал гарахгүй их сайн юм даа гэв.

Лувсандагва гуай тэлд өгөх мөнирлын тэжээлийг хийхдээ 10 литр усанд, тарваганы ходоод 200 грамм, агь ба мангир 250 грамм, ясны нунтаг 900 грамм, хүүхдийн будаа 300 грамм, хөх үнс 200 грамм, хужир, давс 1500 грамм, цагаа 150 грамм, өвсний ханд 500 грамм найруулан хийж 5 литр болтол буцадан хандалж царцаагаад, гараад 3 хоногон тэлд долоолгох журмаар идүүлдэг байна.

Лувсандагва гуай энэ жил төлийн бэлтгэлд зориулж 500 хонийн багтаамжтай саравчтай хашаа 1, хөрвийн байр 3-ыг шөф байгуулагын туслацаатай барьж, нөгөөсөн өс 8 тонн, хужир, шүү 15 тонн, хуурач бууц 10 тонн, овъёос 3 тонн агь, мангир 500 кг, тарваганы сайн ходоод 81 ширхгийг нөөцөлджээ.

Лувсандагва гуай төл болгоныг мал болгоё гэсэн намынхаа дайчин уриа, МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын шийдвэрт улам зоригжиж, өөрийнхөө малласан 100 гаруй хонь, ямааг онд тарган оруулаад үүнээс 500 хонийг нь төлдүүлэх үүрэг авчээ.

Одоо Лувсандагва гуай гэргийтэйгээ хамт 162 хониноос 162 хурга бойжуулаад байна.

үнээний ферм, бригадынхаа гишүүдийн дотор хөдөлмөр зохион байгуулалтыг сайн хийж хүн нэг бүрд тэнцэх ажил хуваарлаж өгсний дүнд ажил нь жигд сайжирчээ.

Тус фермийнхэн 1961 онд 45-250 толгой бод мал багтах дэргэдээ өвс тэжээлийн хашаа, тугалын байртай, 3 тал саравчтай хашаа 4, сайн үүлдрийн бухны дулаан саравч, үхрийн зохиномол хээлтүүлгийн нүүдлийн байр, нүүдлийн ухуулах байрыг тус тус барьсны гадна ногоон өвс 107 тонн, овъёос зүрлэл, манжин байцаа зэрэг бүсэд тэжээлийг 11 дүгээр сарын 15-ны дотор өвөлжөөндөө татан авчээ.

1961 онд фермээрээ саалийн хугацаанд 250 гаруй үнээнээс

### ЗУРГААН ЖИЛ ДАРААЛАН ОНЦ

Манай үеийн хэн боловч өөрийн харнуцсан ажилдаа өндөр бүтээл гаргаж, онц сурахаас илүү эрхэм зорилтгүй гэдгийг сурагч Цэрэням дүүрэн ойлгожээ.

Сурагч Цэрэням онц сурахын үндэс бол багш нарын зааж байгаа хичээл бүрд бүх анхаарлаа төвлөрүүлэн дайчлах явдал болж мөн гэж үздэг байна.

Хэрвээ аль нэг зүйлээс дутуу ойлгосон зүйлээ тэр даруйдаа багшаасаа асууж, лавлаж аваад тэр дор нь сурах бичгээ уншиж жинхэнэ өөрийн болсон бататгаж авдаг. Нөгөө талаар ингэж ойлгож авсан зүйлээ нөхөлдөө ярьж өгдөг нь хоёр талын ашигтай болно.

Нэгд, өөрөө уг хичээлээ хоногшуулж авахад, хоёрт нөхдгийгхөө дутуу ойлгосон зүйлийг нь бататгаж туслах сайн талтай. Ийнхүү ажиллаж ойлгосон хичээл мартагдахгүй болдог гэж онц сурлагатан Цэрэням хэлж байна.

Сурагч Цэрэнимын туршлагаас үзэхэд сурагч хүнд эрэмбэ дараатай, цуцалтгүй нямбай ажиллагааг хичвэн их ач холбогдолтой болох нь илэрхий байна.

### Үхэр фермийнхний а м ж и л т

Алтанбулаг сумын бүгд 102670 литр сүү сааж, Монгол Солонгосын найрамдал сүү ашиглан, зөвхөн 11, 12 дугаар сард 30000 литр сүү сааж, нэгдлийн Лувсан-сүрмэл даргатай 60000 мянган төгрөгийн орлого нэгдэлдээ оруулжээ.

Тус фермийн саальчид шүүст ба нэмэгдэл тэжээлээр үхэр тэжээх аргыг сайн эзэмшиж, манжин, дарш, байцаа, гурилын хивгээр үхэр тэжээдэг заншилтай болжээ.

Энэ фермийнхний бүх үхэр 1961-62 оны өвөл онд тарган орж байна.

Тус фермийн хамт олон МАХН-ын Төв Хорооны 2 дугаар бүгд хурлын шийдвэрийг суллан, 1962 онд их саалийн төлөө, төл болгоныг мал болгохын төлөө, хүч хамтран зүтгэж, төлийн пүнз барьж, хашааны мод бэлтгэх, өвс тэжээл татаж, тугал бойжуулах бэлтгэлийг бүрэн хангаж, одоо үхрийн үс хөөврийг авч байна.

Алтанбулаг сумын зоотехникч Бариацар



ЗУРАГ ДЭЭР: Хоньчин Лувсандагва, гэргий Ц.вэлмаатайгаа хамт сайн гарсан хургаа эхэд нь амлууаж байгаа нь: зургийг Д. Дондогдорж

Тэр, эвлэл, пионер, сургууль, ангийнхаа олон нийтийн ажилд хамгийн идэвхтэй оролцож, тэднээс олон шинэ зүйлийг сурч, өөрийн хичээл сурлагадаа дадлага болгон, гутал хийх, эмнэлгийн анхны мэдэгдэхүүнтэй болох зорилго тавин ажиллаж байна.

Төнийн 10 жилийн дунд сургуулийн 7 дугаар ангийн сурагч Цэрэням 6 жил, 24 улирлийг турш онц суралцан, таван онцыг эзэмшижээ.

Одоо сурагч Цэрэнимын ангидаа сурлагаар хоцорч яваа Цэгмэд, Лхагвасүрэн нарын 4 сурагчийг шөфлэн авч, өөрөө жилийн эцсийн лалалтаа онц өг хөөр нрмүүн ажиллаж байна.

З. Хурээ

### Хорооны ажил сайжирч байна

Архустай сургуулийн комбинант үйлдвэрчний эвлэлийн хороо (дарга нь багш Хандсүрэн) ажилчдын аж байдал материаллаг соёрхлыг нэмэгдүүлж, ажил дээрээ амжилт гаргах нөхцөлийг хангасан шилвэд ажил зохиожээ.

Багш, ажилчдын нормд хэрэглээнд зохих бэрхтэн бээлий, хөвөлтэй өмөд, цамц, өсгий гутал, хөвөнтэй бээлий халайд цөмийг олгуулжээ.

Гэрийн дулаалганд зориулан өсгий дээр, туурга, шалавч олгуулж, зарим багш нарын цалингийн маргааныг барагдуулж, бүх амарвал, зохих багш ажилчдаа цөмий нь амруулсан байна. Түшгэлсэн байгууллагын ажилд туслхаар үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хүчнийг зохион байгуулж, барилгын чулуу кублэж, анги, байруудын 60

гаруй тасалгаа бүхий 10 гаруй байшинд засвар хийж шавардах, булах, гэрэл тавих бүх ажлыг амжилттай дуусгажээ.

Үйлдвэрчний эвлэлийн хороо, сургуулийн мастер багш нарын хооронд уралдаан зарлан, болзол гаргаж ажилласны дүнд сургуулийн 1961-1962 оны ничээлийн жилийн бүх түлшийг 50 гаруй км газраас өөрийн хүчээр татуулсан байна.

Барилга засвар, түлш, татгах ажилд багш Галсандах, Ишжамц нар онц идэвхтэй оролцсон аж.

Гишүүдийн дунд соёл олон түмний ажлыг төрөл бүрийн хөлбэрээр зохиож, түшгэлсэн байгууллагын ажилд үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хүчнийг жигд дайчлан ажиллаж байна.

Д. Чулуун.

### Хууль сурталчлах 3 хоногт

Саяхан аймгийн шүүхээс Борнуур сум-сангийн аж ахуйг гэмт хэргүүд сум-сангийн аж ахуй болгох, танхай балмад явдалтай тэмцэх, социалист өмчийг хамгаалах зорилгоор эрүү, иргэний ба гэр бүл, асрамж тэтгэмжийн тухай хууль сурталчлах 3 хоногийн ажил зохиов.

Үүнд: 9 газар хурал зөвлөлтөөн болж, 1000 шахам хүнийг хамарчээ. Залуу эмэгтэйчүүд, ахмадын зөвлөүүд байгуули, олон нийтийн

шүүхийн тайланг тавиулан, эрүүгийн гэмт хэргийн зарим үйлдлийг харуулсан гар зургийн булан байлган ажиллуулжээ.

Тус аж ахуйн ногооны бригадын дарга Бямба, агротехник Шар, Цэрэндорж, Дугарсүрэн нар өөрсдийн хариуцсан бригад, фермүүдээ гэмт хэрэггүй бригад, ферм болгох үүрэг аваад ажиллаж байна.

Норзол

### Тайлан тооцоог цэгцлэхийн төлөө

Гомбодорж ахлагчийн санхүү, үйлчилгээний ажилчин, СХТ бригад байгуулан социалист ёсоор хамтарч ажиллаж, амьдарч, сурахаар 1 жилийн хугацаатай үүрэг авч ажиллаад уг хугацаа дуусч байна.

Энэ завсар нэг нь ийтийн төлөө нийт нь нэгийн төлөө социалист зан чанарыг өзөмшхээр чин сэтгэлдээ зорьж ажилласны дүнд тайлан бүртгэлийг сайжруулан анхан шатны бүх бүртгэлийг хөтөлж зарим салбарт хууль дүрэм зөрчиж байгааг илрүүлэн засах, хөдөлмөрийн хуудсыг хөтөлж, балансыг хугацаанд нь гаргах, өр дутагдал гаргахгүй байх зэрэг үйлдвэрийн амин чухал асуудал болсон 10 гаруй үүрэг авч биелүүлжээ.

Тус артелийн тайлан баланс зохиц цагтаа бүрэн гарч чаддаг болов.

Урьд онд байсан дутагдал шам-

шигдлыг 95 хувиар багасгаж өр аялагыг 59,9 хувиар хорогдуулан, дутагдал шамингдаа гаргаагүй байна.

Бригад нь авсан үүргээ 137,5 хувиар биелүүлж, төсөв зардлаас 33621 төгрөг хэмнэж 2 хүний ажлыг нэг хүн хийж, галч зарлагын ажлыг бригадын гишүүд хийснээр 1003 төгрөг хэмнэж, ажлын бус цагаар 12 айлын орон сууц барьж, 120000 төгрөгийн хуримтлалыг үйлдвэртээ оруулжээ.

Энэ бригадынхан ажиллаж амьдрах талаар авсан үүргээ амжилттай биелүүлж байна.

Сурах талын зарим үүрэг дутуу байгаа учир тус бригадын хамт олон дутуугаа гүйцээж дулилгаа дүүргэхийн тулд минут алдахгүй шаргуу ажиллах хэрэгтэй байна.

ЖАМБАА

### Төлөвлөгөө биелэв

Мөнгөнморьт сумын худалдаа бэлтгэлийн ангийн төвийн дэлгүүр, 1962 оны 1 дүгээр сарын бараа гүйлгээний төлөвлөгөөг 18.3 хувиар давуулан биелүүлэв.

Худалдагч Санжаасүрэн 100 хувь, Магваан 118,3 хувиар, ном борлуу-

лах төлөвлөгөөг 105,4 хувиар тус тус биелүүлжээ.

Тус дэлгүүрийнхэн хөдөлмөрдөд үйлдлэх цагийн хуваарыг нарийн баримтлан, шуурхай үйлчилсний үрээр ийм амжилтанд хүрчээ.

Ж. Чулуун.

### Сурагчид, төл бойжуулахад

Урхан хавар ирж, түмэн бодис дэлгэрэх цагийн эхэнд хөөлтэй маань хөөлэй дахь төл гарч, алтан дэлхийн хөрсөн дээр гашгэн босч байгаа нь маачин монгол хүмүүсийн уламжлалт их баяр байдаг билээ.

Хонь, ямаан сүрэг өдөр шөнөгүй хэдэн арваараа төллөх нь хүн бүхний хүч чадлыг дайчлах их амжилт шаарддаг. Мэлчдын урам зориг нь улам бадарч, бие нь хөнгөрч, нойр нь сэргэж цагашгүй энэ их хөдөлмөрийн үр дүнд мянга мянган мал нэмэгдэв.

Малын төл хүлээн авч, бүрэн бойжуулах нь социализмын өрнүүн байгуулалтын программыг биелүүлэх олон талт ажлын дотроос гол зүйл мөн.

Энэ ажилд 8 настай балдраас эхлэн, 80 настай буурлууд хүртэл чадлынхаа хирээр нэмэр болж гэсэн эх оронч хөдөлгөөн өрнөдөг.

Манай аймгийн олон сургуулиудын сурагчид малын төл хүлээн авч бойжуулах ажилд асар их хувь нэмэр оруулж байна.

Сурагчид мал өвөлжилт, төлийн бэлтгэлд зориулан 850 нэмнээ, цасны 244 малтуур, 389 бээлий, төлийн 183 уут, 954 өлгөвч бэлтгэж нэгдэл, сангийн аж ахуйд өгчээ.

Батсүмбэр сумын Монхоодой ахагчтай бага сургууль, сангийн аж ахуйн үнээний бригадыг шөфлөн авч хашаа хороог засч дулаалж, тугал бойжуулах арга туршлагыг харуулсан самбар, зурагт хуудсууд хийж өгчээ.

Мөнгөнморьт, Баянжаргалан сумын сургуулиуд нэгдлээсээ 50-100 төллөх хонь, ямаа хүлээн авч өөрсдийн хүчээр төлийг нь бойжуулах гэж байна.

Сургууль бүхэн нэгдлийн бригадуудыг шөфлөн авсан байна.

Багш сурагчдын бүрэлдэхүүнтэй ухуулах бригадуудыг гаргам маачдын дунд ажилуулж байна.

Архуст, Баян, Батсүмбэр сумын сургуулийн сурагчдын сахилга эрх дээшлэж, өнгөрсөн улирлаар сургуулиараа 96-гаас 100 хувийн сурлагын амжилт үзүүлжээ. Энэ сурган сургуулийн 12 багш ангиа 100 хувийн дүнтэй сургажээ.

Ингээж сурагчдын сурлагын чанар сайжраад зогсоогүй, хөдөлмөрдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэхэд энэ сургуулийнхан идэвхтэй ажиллаж, ерөнхий эрдмийн анхан шатны боловсрол олгох 2 жилийн сургууль, оройн

сургуулиудыг байгуулж, сумын төвд суугаа анхан шатны боловсролгүй бүх хүмүүсийг хамарч байна.

ЗУРАГ ДЭЭР: Зүүн гараас Архустын бага сургуулийн эрхлэгч Мажжсүрэн, Баян сумын бага сургуулийн эрхлэгч Гунсаноров, Батсүмбэрийн бага сургуулийн эрхлэгч Монхоодой нар Монголын багш нарын 3 дугаар их хурлын шийдвэрийг яаж биелүүлж байгаа туршлагаа ярилцаж байгаа нь.

Зургийг Давдай.

### ТАЙЛАН СОНГУУЛИЙН ХУРАЛ

Тариат сумын Батхөгжил нэгдлийн бүх гишүүдийн тайлан сонгуулийн хурал саяхан болж, ерөнхий хорооны дарга Доржсүрэн, 1961 оны ажлын дүн ба 1962 онд тавих зорилтын тухай илтгэл тавьлаа.

Доржсүрэн илтгэлдээ: 1961 онд нэгдлийн нийгмийн малыг 104 хувиар, сумын бүх малыг 110 хувиар өсгөсөн ба тус нэгдэлд тэргүүний сайчууд олширч байгааг хийсэн бүтээлээр нь тодорхой дурдаж, 1962 онд бүх малаа өсгөхийн зэрэгцээгээр ашиг шимийн нь нэмэгдүүлж, үүдлөр угсаагийн нь сайжруулан, хөдөлмөрдийн аж амьдралыг улам дээшлүүлэх, үйлдвэр самхүүгийн төлөвлөгөөг яаж биелүүлэх талаар тодорхой ярьлаа.

Одоо мал ид төлөж байгаа үед сурагчид улам их ажил хийх хэрэгтэй болов.

Малчдал захидал бичиж зөвлөлтөө өгөх,ухуулах зурагт хуудас гаргаж түүндээ төл бойжуулах талаар гарч байгаа сайн туршлагыг үзүүлэх, хичээлийн чөлөө цагаар ойр байгаа суурь, бригад фермын төл бойжилтонд биеллэн туслах хэрэгтэй.

Төл бойжуулах ажилд сурагчдыг янз бүрийн хэлбэрээр оролцуулах нь залуу үеийг мал аж ахуйн ажилд дадлагажуулах их ач холбогдолтой юм.

Ийм учраас сурагчдад төл бойжуулж байгаа ажлын арга туршлагыг эзэмшүүлэх ажлыг сургуулиуд тодорхой зохион байгуулбал зохино.

Ялангуяа төл хүлээн авах бэлтгэлийг сайн хангаж төлөө сайн бойжуулж байгаа хот аялагч үзүүлэх арга хэмжээ авах нь чухал.

Дорждамба

Мөн хариуцсан суурь хонно 5 сар оторлож уйгагүй дагаж хариуцсаны үр дүнд хонь бүрийг дундаар 40-45 кг-д хүргэсэн, хоньчин Рэнцэн, Жагд, Цэрмаа, Ням нар болон, нэгдлийн үйлдвэрийн төлөвлөгөөг биелүүлэхэд их амжилт гаргасан Жавзмаа, Нөржин, Цэрэндорж, Дамба нарын 40 гаруй хүнийг сайшаалын үнэмлэх, «Эх орон 52» хүлээн авчга зэрэг үнэ бүхий зүйлээр шагналаа.

Хуралд тус нэгдлийн шөф, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн удирдлагууд болон, Лүн сумын дарга, тамын үүгийн дарга нар урилгаар оршиов.

Дараа нь махкомбинатын уран сайханчдын концерт тоглов.

Г. Базарсад